ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
41000 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс:70272582, e-mail: tuv@audit.gov.mn

2018. 02. 15 № 1/44

танай_____-ны №_____-т

ТӨВ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Ж.ОТГОНЧУЛУУН
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Статистикийн хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Статистикийн хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын батлсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төв аймгийн Статистикийн хэлтсийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын батлсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТӨВ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор

Ц.Хишигжаргал

И-мейл: khj_616@yahoo.com

Утас: 70272582

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мейл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор

Т.Майцэцэг

Утас: 70273204 99018619

И-Мейл: maits2009@yahoo.com

Төв аймаг дахь төрийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын 2-р ордон

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 2 дугаар сар 13

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Статистикийн хэлтсийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд / ТӨВ-2017/200/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Статистикийн хэлтсийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай болон нийцлийн аудит 4200 стандарттай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Статистикийн хэлтсийн 2017 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 2018 оны 02 дүгээр сарын 15-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн ахлах аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Статистикийн хэлтэс нь 2017 оны төсвийн санхүүгийн тайланг 2018 оны 01 дугаар сарын 15-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 2018 оны 02 дүгээр сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 15 -нд Төв аймгийн Статистикийн хэлтсийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Статистикийн тухай хууль, хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Статистикийн тухай хуулийн 1-р зүйлд Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, статистикийн байгууллага, мэдээлэгчийн бүрэн эрхийг тогтоож, тэдгээрийн хооронд болон хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр хангах явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.11 дүгээр зүйлийн 1-д Статистикийн байгууллага нь улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн эдийн засаг, хүн ам, нийгэм, байгаль орчны талаарх статистикийн мэдээллээр төр, иргэн, аж ахуйн нэгж, байгуулагад адил тэгш үйлчилдэг төрийн байгууллага мөн гэж заасны дагуу тухайн байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Төсөв нь статистикийн үйл ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна. Статистикийн үйл ажиллагааг сум, баг, хороонд эрхлэн явуулахтай холбогдон гарах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. гэж заасан энэхүү төсөв нь уг байгууллага үүрэг, зорилтоо бүрэн хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.38-д "төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18.төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна гэж заасны дагуу Төв аймгийн Статистикийн хэлтсийн дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг ҮСХ-оос баталж Төв аймгийн төрийн сангаар олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Статистикийн тухай хууль үйл ажиллагаатай холбогдсон хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Статистикийн хэлтсийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Статистикийн хэлтсийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын 2 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ҮСХ-аас боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Өмнөх аудитаар бэлэн мөнгөний тайланг Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын дагуу тайлагнаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт", 14 дүгээр зүйл "Нягтлан бодох бүртгэл хөтлөх" гэж заасныг болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хугацаанд гаргаж, ирүүлсэн.

ҮСХ-ны даргын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичигтэй нийцэж байгаа болно. Бүртгэлийн acolous програм ашигладаг энэ нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Статистикийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж хянахад Санхүүгийн үйл ажиллагаанд ҮСХорооны дотоод аудит хяналт шинжилгээ үнэлгээний газраас хяналт шалгалт хийгдээгүй байна. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Статистикийн хэлтсийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 95384.3 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 83441.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан. Мөнгөн гүйлгээний тайлангаар 172239.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 11732.4 мянган төгрөгөөр төсөвт татан төвлөрүүлж, төвлөрүүлэх шилжүүлгээр тайлагнасан байна

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ҮАГ-аас нэгдсэн удирдамжаар 2017 оны 10-р сарын байдлаар хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар тус байгууллагын мэдээллийг шалгасан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 2 хяналтын эрсдэлийг тогтоож, Гүйцэтгэлийн шатанд 3 дансанд горим сорилыг хэрэгжүүлж, мэдээллийг СТАУС программд оруулж гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Статистикийн хэлтсийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. ҮСХ-ноос шилжиж ирсэн компьютерийг данс бүртгэлд тусгахдаа 1372.3 мянган төгрөгийг өмнөх үеийн үр дүн дансанд бичсэн нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, УСНББОУС 17, 23 -ийн холбогдох заалттай нийцэхгүй байна

   Шийдвэрлэсэн: Алдааг зөвшөөрч аудитын явцад залруулав.

2. Санхүү үр дүнгийн тайланд НД-ийн сангаас олгосон 5146.9 мянган төгрөгийг эх үүсвэрээр тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас батлсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, УСНББОУС 2 -ийн 32 дахь заалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Алдааг зөвшөөрч аудитын явцад залруулав.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 6519.2 мянган төгрөгийн материаллаг бус алдаа залруулагдсан.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн байгууллагын 2017 оны санхүүгийн тайлангийн явцад эрсдэлтэй гэж төлөвлөгдсөн горим сорилыг хэрэгжүүлсэн ба аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Статистикийн хэлтсийн урсгал төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 1372.3 мянган төгрөгийн, материаллаг бус 5146.9 мянган төгрөгийн буюу нийт 6519.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан. Аудитаар зөвлөмж, акт, албан шаардлага өгөгдөөгүй болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймаг дахь Төрийн аудитын газраас Статистикийн хэлтсийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2017.06.15-ний өдрийн №11 тоот албан бичгээр ирүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Төв аймгийн Статистикийн хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын батлсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Ц.ХИШИГЖАРГАЛ**

АУДИТЫН МЕНЕЖЕР **О.АМАРЖАРГАЛ**

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР **Т.МАЙЦЭЦЭГ**